



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 372

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 411, 198 дугаар  
тогтоолоор батлагдсан журмуудад  
нэмэлт, өөрчөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 5 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 3 дахь заалтын “даатгуулагчид” гэснийг “даатгуулагчийн эрх бүхий албан тушаалтанд”, “даатгагчид” гэснийг “даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 5 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 12 дахь хэсгийг нэмсүгэй:

“5.12. Даатгагч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлсэн хөлс, төлбөрийг арилжааны банк дахь даатгалын төлөөлөгчийн дансанд бэлэн бусаар шилжүүлэн олгоно” гэж.

3. Энэ тогтоолыг 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001006